



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

*Эрчим хүчний сайдын төсвийн багцын
2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит*

Аудитын код: УАГ-САГ/2015/34/СТА-ТЕЗ

Улаанбаатар хот
2015 оны 4 дүгээр сар



ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫН ТӨСВИЙН БАГЦЫН 2014 ОНЫ САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

YAG-ын Санхүүгийн аудитын газрын
дарга,
Тэргүүлэх аудитор С.Энхзаяа
Утас: 261663
Цахим хаяг:
enkhzayas@audit.gov.mn

Аудитын менежер:Ц.Ойдов
Утас: 260512
Цахим хаяг:oidovts@audit.gov.mn

Ахлах аудитор: Д.Ганбилэг
Утас: 261885
Цахим хаяг:
ganbilegd@audit.gov.mn

Аудитор: Б.Сэржмядаг
Утас: 261885
Цахим хаяг:
serjmyadagb@audit.gov.mn

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр
Бага тойруу 3
Улаанбаатар-15160
Монгол Улс

Цахим хаяг: www.audit.mn

1. АУДИТЫН ТАЙЛАН

2. АУДИТЫН ГЭРЧИЛГЭЭ

3.МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Хавсралт 1: Аудит хийгдсэн санхүүгийн
байдлын тайлан

Хавсралт 2: Аудит хийгдсэн санхүүгийн үр
дүнгийн тайлан

Хавсралт 3: Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний
тайлан

Хавсралт 4: Аудит хийгдсэн цэвэр
хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хавсралт 5: Аудит хийсэн төсвийн
гүйцэтгэлийн тайлан

2015 оны 4 дүгээр сар

АУДИТЫН ТАЙЛАН

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллаг байдал
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Зөвлөмж
18. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5, Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд /ҮАГ-2015/34/СТА-ТЕЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэв.

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2015 оны 4 дүгээр сарын 6-ны өдрөөс 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд хийхээр төлөвлөн Үндэсний аудитын газрын САГ-ын 3 дугаар багийн ахлах аудитор Д.Ганбилэг, аудитор Б.Сэржмядаг нар хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг 2015 оны 4 дүгээр сарын 3-ны өдөр Үндэсний аудитын газарт ирүүлсэн байна.

Үндэсний аудитын газар аудитыг 2014 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс 2015 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн хооронд гүйцэтгэж, тайланг 2015 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Эрчим хүчний сайдад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин

Эрчим хүчний сайд нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Монгол улсын засгийн газрын тухай”, “Эрчим хүчний тухай”, “Сэргээгдэх эрчим хүчний тухай”, “Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай”, “Концесийн тухай”, “Төрийн албаны тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа эрхлэж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа

Эрчим хүчний яам нь Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжлийн өсөлтийг хангахуйц эрчим хүчний бодлогыг хэрэгжүүлж, хүний эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд амьдрах болон үйлдвэрлэл, үйлчилгээний найдвартай, тогтвортой нөхцлийг хангахад оршино.

Эрчим хүчний сайд нь Эрчим хүчний яамыг тэргүүлж, эрх хэмжээнийхээ асуудлаар хууль, Улсын Их хурлын тогтоол болон бусад шийдвэрт нийцүүлэн тушаал гаргаж, биелэлтийг хангах, Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасан:

- Эрчим хүчний нэгдсэн бодлого
- Эрчим хүчний үйлдвэрлэлт, дамжуулалт, түгээлтийн асуудал
- Сэргээгдэх эрчим хүчийг хөгжүүлэх асуудал
- Эрчим хүчний шинэ эх үүсвэрийг бий болгох, ашиглах бодлого
- Түлш (эрчим хүч нүүрс)-ний хангамж, нөөцийн бодлого, зохицуулалтын асуудлыг хариуцсан бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ өөрийн ажлын хэсэг, тэргүүлж буй яамныхаа аппаратад түшиглэн эрхлэх асуудлынхаа хүрээний чиглэлээр зөвөлгөө, туслалцаа авч, яам агентлаг, Засгийн газраас байгуулсан бусад байгууллагын үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангана.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-д “дараах албан тушаалтан төсвийн ерөнхийлөн захирагч байна”, 14.1.8-д “Засгийн газрын гишүүн холбогдох төрийн захиргааны төв байгууллагын болон түүнд хууль тогтоомжоор харьяалуулсан бусад байгууллагын төсвийн өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах” гэж заасны дагуу Эрчим хүчний сайд нь Эрчим хүчний яамны 2014 оны төсвийн багцыг Сангийн яамны төрийн сангаар дамжуулан зарцуулж байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн баримт бичиг болох Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Монгол Улсын засгийн газрын тухай хууль, Эрчим хүчний тухай хууль, Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль, Цахилгаан, дулааны эрчим хүч, нүүрсний төлбөрийн тухай хууль, Концесийн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийг тус тус хэрэгжүүлэн ажиллаж байна.

Эрчим хүчний яамны үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн

Аудитыг гүйцэтгэхдээ Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Эрчим хүчний яамны санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулсан боловч холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй байна.

Эрчим хүчний яамны санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Эрчим хүчний яамны санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу гаргасан байна.

Материаллаг байдал

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлын түвшинг 1 хувиар тооцсон. Эрчим хүчний сайдын төсвийн багцын нийт хөрөнгө, цэвэр хөрөнгөөр авч үзсэн материаллаг түвшин өндөр гарч байгаа тул гүйцэтгэлийн үе шатанд нийт зардлын 2 хувиар тооцох нь зохимжтой гэж үзэж материаллаг байдлын түвшинг 3,991.8 сая төгрөгөөр тогтоов.

Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр давтан хийсэн нь жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Эрчим хүчний яамны дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин авч үзэхэд дотоод хяналттай байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2014 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Эрчим хүчний сайд нь 2014 онд улсын төсвөөс урсгал зардалд 32,014.2 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 34,511.9 сая төгрөг батлагдсанаас 31,872.7 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 2,639.2 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн дагуу төсвийн болон улс, орон нутгийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах зорилгоор төсвийн удирдлагын шийдвэр, үйл ажиллагаа ил тод, нээлттэй, ойлгомжтой байх, түүнд олон нийт хяналт тавих мэдээллийн тогтолцоог хуулийн дагуу хангахаар зорилт тавин ажиллаж /холбоос:<http5//shilendans.mn.gov.mn/> вэб хуудсанд шилэн дансыг байршуулсан.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 13 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 17 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал:

Санхүүгийн тайланг 3,159.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн. Нийт 1,738.4 сая төгрөгийн авлага, 1,507.1 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зэрэг нь үнэн зөв, хэмжилт, толилуулга ба тодруулга зэрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлхүйц хэмжээний хөрөнгө бусад дансад, ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 29.4 хувь, мөнгөн хөрөнгийн 11,7 хувь, нийт зардлын 63 хувь, нийт хөрөнгийн 43 хувийг тус тус эзэлж байна.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Санхүүгийн тайланг бэлтгэхдээ нийт хөрөнгийг 3,159.8 сая, цэвэр хөрөнгийг 2,456.3 сая, үйл ажиллагааны орлогыг 293.1 сая, тайлангийн үеийн үр дүнг 2,357.6 сая төгрөгөөр тус тус дутуу харин үйл ажиллагааны зардлыг 2,064.5 сая, үйл ажиллагааны мөнгөн орлогыг 28,910.3 сая, үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээг 30,498.7 сая, хөрөнгө оруулалтын цэвэр мөнгөн гүйлгээг 30,507.9 сая төгрөгөөр тус тус илүү илэрхийлсэн байна

Шийдвэрлэсэн: НББТХуулийг мөрдөж, санхүүгийн тайлан тэнцлийг УСНББОУС-ын дагуу гаргах, зөвлөмж өгөх.

2. Авлагын дансад бүртгэлтэй нийт 2,844.9 сая төгрөгийн 61.1 хувь буюу 1,738.4 сая төгрөг, өглөгийн дансад бүртгэлтэй нийт 14,051.6 сая төгрөгийн өглөгийн 10.7 хувь буюу 1,507.1 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах, авлага өглөгийг баталгаажуулах талаар зөвлөмж өгөх.

3.Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн тайланд өмнөх үеийн үр дүнг 7,915.8 сая төгрөгөөр илүү илэрхийлж 7,230.2 сая төгрөгийг аудитын явцад залруулсан боловч 685.5 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Тавантолгойн Дулааны цахилгаан станц төсөл хэрэгжүүлэх нэгж өмнөх үеийн үр дүнг 286.5 сая, ЭХХТөв 157.6 сая төгрөгөөр тус тус өөрчилсөнтэй холбоотой байна. Төсөл дуусч тайлан гаргаагүй Дэлхийн банкны нэмэлт санхүүжилтийн төслийн хуримтлагдсан үр дүн 814,5 сая төгрөгөөр тус тус зөрсөн. Байна.

Шийдвэрлэсэн: НББТХуулийг мөрдөж, санхүүгийн тайлан тэнцлийг СТОУС-ын дагуу гаргах, зөвлөмж өгөх.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Эрчим хүчний сайдын төсвийн багцын нэгтгэсэн тайлангийн авлагын дансад бүртгэлтэй нийт 2,844.9 сая төгрөг байгаагаас 1,738.4 сая төгрөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй бөгөөд түүний 69 хувь буюу 1,201.3 сая төгрөг нь ЭХХТөв ТӨААТҮГ-т ногдож байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаас харахад цаашид тайланд оноос өмнөх онуудын өмчийн өөрчлөлтийн тайлан Засгийн газрын хувь оролцоо, хуримтлагдсан үр дүн, мөнгөн хөрөнгө, авлагын үлдэгдлийн баталгаажуулалтыг үргэлжлүүлэн нарийвчлан шалгах.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Эрчим хүчний сайдын багцын төсвийн багцын 2014 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 7,090.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 3,159.8 сая төгрөгийг залруулж, 3,931.0 сая төгрөгийн зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2013 оны санхүүгийн тайланг баталгаажуулах явцад өгсөн 5 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй, нэг албан шаардлагын биелэлт хангагдаагүй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг, Төсвийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлэгдсэн гэж үзэн Зөрчилгүй санал дүгнэлт өгөхийг Монгол Улсын Ерөнхий аудиторт санал болгож байна.



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД
Д.ЗОРИГТ ТАНАА

2015.04.24 № 801
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Төсвийн ерөнхийлөн захирагч нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.3-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн нэгтгэсэн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудыг Төсвийн тухай болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, тэдгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Зөрчилгүй санал дүгнэлт

Эрчим хүчний сайдын төсвийн багцын 2014 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, шударга илэрхийлсэн байна.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

Санхүүгийн аудитын газар-А4 бланк

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1

Өмнөх үеийн үр дүнгийн талаар

Асуудал 2

Авлага, өр төлбөрийн талаар

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Эрчим хүчний яамны сайдад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Эрчим хүчний яамны СХОГ-ын ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ын ажиглалт

2014 оны санхүүгийн тайланд өмнөх үеийн үр дүнг 7,915.8 сая төгрөгөөр илүү илэрхийлж 7,230.2 сая төгрөгийг аудитын явцад залруулж 685.5 сая төгрөгөөр зөрүүтэй байгаа нь Тавантолгойн дулааны цахилгаан станцын төсөл хэрэгжүүлэх нэгж өмнөх үеийн үр дүнг 286.5 сая, ЭХХТөв 157.6 сая төгрөгөөр тус тус өөрчилсөн. Дэлхийн банкны нэмэлт санхүүжилтийн төсөл дуусч санхүүгийн тайлан гараагүйгээс хуримтлагдсан үр дүн 814.5 сая төгрөгөөр зөрүүтэй байна.

ҮАГ-ын зөвлөмж

УСНББОУС, Нятлан бодох бүртгэлийн тухай хуулийг мөрдөж ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх, үнэн зөв батламж мэдэгдэл хангахгүй байх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Авлага, өр төлбөр	Тэргүүлэх ач холбогдол №1
-------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Авлагын дансад бүртгэлтэй нийт 2,844.9 сая төгрөгийн 61.1 хувь буюу 1,738.4 сая төгрөг, өглөгийн дансад бүртгэлтэй нийт 14,051.6 сая төгрөгийн өглөгийн 10.7 хувь буюу 1,507.1 сая төгрөгийг тус тус тооцоо нийлж баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19.1.4. "эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

ҮАГ-ын зөвлөмж

Авлага өглөгийг тооцоо нийлэх, барагдуулах арга хэмжээ авч ажиллах

Эрсдэлүүд

Санхүүгийн тайланд он дамжсан баталгаажаагүй өр, авлага үүсч үр дүнд сөргөөр нөлөөлөх

Төсвийн захирагчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

БАЛАНСЫН ЗҮЙЛ	2014.01.01 ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	2014.12.31 ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	АУДИТААР ЗАЛРУУЛСАН	2014.12.31 АУДИТ ХИЙГДСЭН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
МӨНГӨН ХӨРӨНГӨ	7,532,041,355.81	29,462,777,318.70	9,211,057.20	29,471,988,375.90
КАССАНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ	46,664,353.33	24,691,549.54	1,016,424.00	25,707,973.54
ТӨГРӨГ ЖМС	46,664,353.33	24,691,549.54	1,016,424.00	25,707,973.54
БАНКИНД БАЙГАА БЭЛЭН МӨНГӨ	7,485,377,002.48	29,438,085,769.16	8,194,633.20	29,446,280,402.36
ТӨГРӨГ	7,485,377,002.48	29,438,085,769.16	8,194,633.20	29,446,280,402.36
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ХАРИЛЦАХ	5,901,530,693.30	8,145,893,552.30	-	8,145,893,552.30
ТӨСӨВТ БАЙГУУЛЛЫН ХАРИЛЦАХ (АРИЛЖААНЫ БАНК)	1,583,846,309.18	21,292,192,216.86	8,194,633.20	21,300,386,850.06
АВЛАГА	2,714,358,801.21	2,095,759,452.82	749,143,226.51	2,844,902,679.33
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН АВЛАГА	272,589.74		5,839,031.53	5,839,031.53
БУСАД АВЛАГА	2,714,086,211.47	2,095,759,452.82	743,304,194.98	2,839,063,647.80
БАЙГУУЛЛАГААС АВАХ АВЛАГА	2,714,086,211.47	2,089,404,676.11	743,304,194.98	2,832,708,871.09
ТҮЛШ ХАЛААЛТЫН АВЛАГА		25,663,943.00	-	25,663,943.00
БУСАД ЗАРДЛЫН ТООЦООНЫ АВЛАГА	2,714,086,211.47	2,063,740,733.11	743,304,194.98	2,807,044,928.09
ХУВЬ ХҮМҮҮСЭЭС АВАХ АВЛАГА		6,354,776.71	-	6,354,776.71
УРЬДЧИЛГАА	1,614,337,043.68	12,791,630,327.42	2,347,261,700.36	15,138,892,027.78
БУСАД УРЬДЧИЛГАА	1,614,337,043.68	12,791,630,327.42	2,347,261,700.36	15,138,892,027.78
УРЬДЧИЛЖ ГАРСАН ЗАРДАЛ	1,614,337,043.68	12,791,630,327.42	2,347,261,700.36	15,138,892,027.78
УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ	1,614,337,043.68	12,791,630,327.42	2,347,261,700.36	15,138,892,027.78
БАРАА МАТЕРИАЛ	809,523,492.49	1,278,556,147.04	38,205,750.12	1,316,761,897.16
ТҮҮХИЙ ЭД МАТЕРИАЛ	89,512,500.00	29,107,100.00	-	29,107,100.00
ТУСГАЙ ЗОРИУЛАЛТТАЙ МАТЕРИАЛ	89,512,500.00	29,107,100.00	-	29,107,100.00
ХАНГАМЖИЙН МАТЕРИАЛ	720,010,992.49	1,249,449,047.04	38,205,750.12	1,287,654,797.16
БИЧИГ ХЭРГИЙН МАТЕРИАЛ	11,688,953.36	17,090,145.45	-	17,090,145.45
АЖ АХУЙН МАТЕРИАЛ	12,547,604.89	28,142,692.41	-	28,142,692.41
СЭЛБЭГ ХЭРЭГСЭЛ	458,737,558.69	445,815,531.46	-	445,815,531.46
ТҮЛШ, ШАТАХ ТОСЛОХ МАТЕРИАЛ	5,290,200.00	8,907,649.22	-	8,907,649.22
БАРИЛГЫН ЗАСВАРЫН МАТЕРИАЛ	6,691,046.00	4,485,046.00	-	4,485,046.00
БУСАД БАРАА МАТЕРИАЛ	225,055,629.55	745,007,982.50	38,205,750.12	783,213,732.62
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	12,670,260,693.19	45,628,723,245.98	3,143,821,734.19	48,772,544,980.17
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	225,855,060,089.71	320,510,592,456.48	16,027,399.26	320,526,619,855.74
БИЕТ ХӨРӨНГӨ	225,608,899,930.29	320,262,887,604.00	14,527,399.26	320,277,415,003.26
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ, ОРОН СУУЦ	1,856,799,458.91	2,974,675,581.35	-	2,974,675,581.35
БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ ОРОН СУУЦ - АНХНЫ ӨРТӨГ	3,845,480,805.10	4,593,188,629.10	-	4,593,188,629.10

БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ ОРОН СУУЦ - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-1,988,681,346.19	-1,618,513,047.75	-	-1,618,513,047.75
АВТО-ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ	1,582,534,830.54	1,561,113,867.69	-	1,561,113,867.69
АВТО-ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ АНХНЫ ӨРТӨГ - АНХНЫ ӨРТӨГ	1,959,295,210.45	2,343,792,098.91	-	2,343,792,098.91
АВТО-ТЭЭВРИЙН ХЭРЭГСЭЛ - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-376,760,379.91	-782,678,231.22	-	-782,678,231.22
МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ(КОМПЬЮТЕР)	1,559,250,371.87	1,525,470,378.91	-	1,525,470,378.91
МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ(КОМПЬЮТЕР) - АНХНЫ ӨРТӨГ	2,243,604,185.83	2,577,501,486.35	-	2,577,501,486.35
МАШИН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ(КОМПЬЮТЕР) - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-684,353,813.96	-1,052,031,107.44	-	-1,052,031,107.44
ТАВИЛГА, АЖ АХУЙН ЭД ХОГШИЛ	693,894,869.81	886,644,445.31	14,527,399.26	901,171,844.57
ТАВИЛГА, АЖ АХУЙН ЭД ХОГШИЛ - АНХНЫ ӨРТӨГ	1,033,609,084.80	1,331,181,622.79	17,742,010.91	1,348,923,633.70
ТАВИЛГА, АЖ АХУЙН ЭД ХОГШИЛ - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-339,714,214.99	-444,537,177.48	(3,214,611.65)	-447,751,789.13
БУСАД ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,461,463.33	12,591,578.83	-	12,591,578.83
БУСАД ҮНДСЭН ХӨРӨНГӨ - АНХНЫ ӨРТӨГ	21,407,560.00	21,407,560.00	-	21,407,560.00
БУСАД ҮНДСЭН ХӨРӨНГӨ - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-3,946,096.67	-8,815,981.17	-	-8,815,981.17
ДУУСААГҮЙ БАРИЛГА, БАЙГУУЛАМЖ	219,898,958,935.83	313,302,391,751.91	-	313,302,391,751.91
БИЕТ БУС ХӨРӨНГӨ	246,160,159.42	247,704,852.48	1,500,000.00	249,204,852.48
ПРОГРАМ ХАНГАМЖ	56,101,826.04	55,717,352.54	1,500,000.00	57,217,352.54
ПРОГРАМ ХАНГАМЖ - АНХНЫ ӨРТӨГ	66,881,029.00	79,178,483.55	1,500,000.00	80,678,483.55
ПРОГРАМ ХАНГАМЖ - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-10,779,202.96	-23,461,131.01	-	-23,461,131.01
БУСАД БИЕТ БУС ХӨРӨНГӨ	190,058,333.38	191,987,499.94	-	191,987,499.94
БУСАД БИЕТ БУС ХӨРӨНГӨ - АНХНЫ ӨРТӨГ	191,550,000.00	194,550,000.00	-	194,550,000.00
БУСАД БИЕТ БУС ХӨРӨНГӨ - ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ	-1,491,666.62	-2,562,500.06	-	-2,562,500.06
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	238,525,320,782.90	366,139,315,702.46	3,159,849,133.45	369,299,164,835.91
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	11,251,178,390.47	13,348,098,325.77	703,493,336.53	14,051,591,662.30
БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛИЙН ӨГЛӨГ	2,730,053,000.00		-	
ГАДААД ВАЛЮТ	2,730,053,000.00		-	
ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА	2,730,053,000.00		-	
ТӨСЛИЙН ЗЭЭЛ	2,730,053,000.00		-	
ӨГЛӨГ	8,460,372,409.94	12,317,019,944.24	655,186,477.87	12,972,206,422.11
АЖИЛЧИДТАЙ ХОЛБОГДСОН ТООЦОО		404,337.49	16,555,816.70	16,960,154.19
ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ		60,000.00	4,223,043.00	4,283,043.00
НДШ-ИЙН ӨГЛӨГ			12,332,773.70	12,332,773.70
ХАОАТ-ЫН ӨГЛӨГ		344,337.49	-	344,337.49
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДЛЫН ТООЦОО	75,747,500.08	17,621,162.40	49,000,735.77	66,621,898.17
БУСАД ЗАРДЛЫН ТООЦОО	75,747,500.08	17,621,162.40	49,000,735.77	66,621,898.17
БУСАД ӨГЛӨГ	8,384,624,909.86	12,298,994,444.35	589,629,925.40	12,888,624,369.75
БАЙГУУЛЛАГАД ТӨЛӨХ ӨГЛӨГ	8,384,624,909.86	12,298,994,444.35	589,629,925.40	12,888,624,369.75
УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО	60,752,980.53	1,031,078,381.53	48,306,858.66	1,079,385,240.19
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГА		929,286,369.00	-	929,286,369.00

ЗУРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО		929,286,369.00	-	929,286,369.00
БУСАД УРЬДЧИЛЖ ОРСОН ОРЛОГО	60,752,980.53	101,792,012.53	48,306,858.66	150,098,871.19
237 УРТ ХУГАЦААТ ӨР, ТӨЛБӨР	20,432,660,130.71	41,305,830,408.49	-	41,305,830,408.49
УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ	20,432,660,130.71	41,305,830,408.49	-	41,305,830,408.49
ГАДААД ВАЛЮТ	20,432,660,130.71	41,305,830,408.49	-	41,305,830,408.49
ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС	3,731,110,140.00	41,305,830,408.49	-	41,305,830,408.49
ТӨСЛИЙН ЗЭЭЛ	3,731,110,140.00	41,305,830,408.49	-	41,305,830,408.49
БУСАД ГАДААД ЭХ ҮҮСВЭР	16,701,549,990.71		-	
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	31,683,838,521.18	54,653,928,734.26	703,493,336.53	55,357,422,070.79
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУВЬ ОРОЛЦОО	206,841,482,261.72	311,485,386,968.20	2,456,355,796.92	313,941,742,765.12
ЗАСГИЙН ГАЗРЫН ОРУУЛСАН КАПИТАЛ /ЗАСГИЙН ГАЗРЫН САН/ ОРОН НУТГИЙН САН	199,719,610,736.57	301,724,752,527.92	7,329,022,832.66	309,053,775,360.58
ХУРИМТЛАГДСАН ҮР ДҮН	5,440,189,991.43	8,078,952,906.56	(4,872,667,035.74)	3,206,285,870.82
ӨМНӨХ ҮЕИЙН ҮР ДҮН	5,440,189,991.43	13,355,992,741.94	(7,230,263,518.94)	6,125,729,223.00
ТАЙЛАНТ ҮЕИЙН ҮР ДҮН		-5,277,039,835.38	2,357,596,483.20	-2,919,443,352.18
ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ЗӨРҮҮ	1,681,681,533.72	1,681,681,533.72	-	1,681,681,533.72
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	206,841,482,261.72	311,485,386,968.20	2,456,355,796.92	313,941,742,765.12
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	238,525,320,782.90	366,139,315,702.46	3,159,849,133.45	369,299,164,835.91

АУДИТ ХИЙГДСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

2014 оны 12 сарын 31-ний байдлаар

/төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН	АУДИТААР ЗАЛРУУЛСАН	АУДИТ ХИЙГДСЭН ДҮН 2014.12.31
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	159,787,185,754.95	181,014,665,032.00	-	181,014,665,032.00
Засгийн газрын бусад түвшнээс авах тусламж санхүүжилт	159,787,185,754.95	181,014,665,032.00	-	181,014,665,032.00
Улсын төвлөрсөн төсвөөс	130,561,861,297.00	163,933,100,985.00	-	163,933,100,985.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	37,639,707,892.00	32,014,283,850.00	-	32,014,283,850.00
Засгийн газрын нөөц хөрөнгө	854,000,000.00		-	-
Хөрөнгийн	92,025,537,011.00	131,918,817,135.00	-	131,918,817,135.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	42,616,394.00		-	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захи	12,525,694.00		-	-
Төсвийн урамшуулал	30,090,700.00		-	-
Төсөвт байгууллагаас	21,790,454,638.00		-	-
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт			-	-
Хөрөнгийн	21,790,454,638.00		-	-
Бусад Засгийн газрын тусгай зориулалтын сангаас санхүүжих	7,434,869,819.95	17,081,564,047.00	-	17,081,564,047.00
Гадаад төслийн зээлээс санхүүжих	7,434,869,819.95	17,081,564,047.00	-	17,081,564,047.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	8,408,810,188.15	11,992,468,849.47	293,095,395.10	12,285,564,244.57
Бараа, үйлчилгээний борлуулалт	8,408,810,188.15	11,992,468,849.47	293,095,395.10	12,285,564,244.57
Төсөвт байгууллагуудын ажил, үйлчилгээний орлого	8,408,810,188.15	11,992,468,849.47	293,095,395.10	12,285,564,244.57
Үндсэн үйл ажиллагааны орлого	7,769,610,181.59	11,516,495,458.31	291,603,522.71	11,808,098,981.02
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	639,200,006.56	475,973,391.16	1,491,872.39	477,465,263.55
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	168,195,995,943.10	193,007,133,881.47	293,095,395.10	193,300,229,276.57
АЖИЛЛАГСДЫН ЗАРДАЛ	3,947,752,704.20	7,906,050,341.57	-	7,906,050,341.57
Үндсэн болон нэмэгдэл цалин	3,566,382,505.23	7,073,255,792.92	-	7,073,255,792.92
Үндсэн цалин	3,053,913,659.21	6,623,611,130.24	-	6,623,611,130.24
Гэрээт ажилчдын цалин	186,436,968.50	47,448,000.00	-	47,448,000.00
Бусад нэмэгдлүүд	326,031,877.52	402,196,662.68	-	402,196,662.68
Үр дүнгийн урамшуулал	239,262,647.52	325,984,104.68	-	325,984,104.68
Унаа, болон бусад нөхөн олговор	86,769,230.00	76,212,558.00	-	76,212,558.00
Нийгмийн хамгааллын шимтгэл	381,370,198.97	832,794,548.65	-	832,794,548.65
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	360,955,086.97	685,404,297.34	-	685,404,297.34
Тэтгэврийн даатгалын шимтгэл	340,153,323.97	537,444,627.38	-	537,444,627.38

Тэтгэмжийн даатгалын шимтгэл	8,387,338.00	53,427,043.81	-	53,427,043.81
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	10,369,959.00	74,012,321.31	-	74,012,321.31
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	2,044,466.00	20,520,304.84	-	20,520,304.84
Эрүүл мэндийн даатгалын хураамж	20,415,112.00	147,390,251.31	-	147,390,251.31
УРСГАЛ ЗАРДАЛ	8,392,242,885.82	13,563,384,278.04	(2,064,501,088.10)	11,498,883,189.94
